

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2025/11/25

Дуусах хугацаа: 2025/12/12

Ажил эхлэх хугацаа: 2025/12

Цалин: Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Байгууллагын дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах, жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах;
- Байгууллагын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг нэгтгэн дотоод хяналт, дүн шинжилгээ хийж, үр дүнг тайлагнах;
- Байгууллагын үйл ажиллагаанд хийгдэх аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах.

Тавигдах шаардлага:

- Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- Дотоод хяналт, шалгалтын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх;
- Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх;
- Мэдээлэл боловсруулах, судалгаа хийх, дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулах, тайлан гаргах чадвартай байх;
- Олон улсын стандартын дотоод аудитор бол давуу тал болно;
- Англи хэлний бичгийн болон ярианы B1 ба түүнээс дээш түвшний мэдлэгтэй бол давуу тал болно.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл;
- Товч намтар – CV;
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар;
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь.

Холбоо барих:

Та баримт бичгээ англи эсхүл монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярицлагад урих болно.